

Улаангом хотын хоёрдугаар станц



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Компанийн үндсэн үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлсэн, шат шатны хяналт хангалтгүй байгаа нь компанийн засаглалыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

АУДИТЫН СЭДЭВ: "УЛААНГОМЫН ДУЛААНЫ
ХОЁРДУГААР СТАНЦ" ТӨХК-ИЙН 2020-2022 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН
АУДИТЫН КОД: УВА-2023/46-ШТА-ГА

УЛААНГОМ ХОТ

2023 ОН

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3-4
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	5
Аудитын менежер М.Бат-Амгалан	Хүснэгтийн жагсаалт	5
Ахлах аудитор Б.Авирмэд Т.Намжил С.Батсайхан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	6-7
Аудитор Б.Одгэрэл Т.Золоо Т.Амармэнд Ч.Мөнхтогтох	Бүлэг 1. Аж ахуйн нэгжүүдийг дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дулаан түгээх эзлэхүүнийг зөрүүтэй тусгаснаас орлого дутуу төвлөрүүлсэн байна.	8
	1.1 Аж ахуйн нэгжүүдийг дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дулаан түгээх эзлэхүүнийг зөрүүтэй тусгаснаас орлого дутуу төвлөрүүлсэн байна.	8-9
	1.2. Компанийн алдагдалд дүн шинжилгээ хийж татаас санхүүжилтийг төлөвлөн батлуулаагүй байна.	9
	1.3. Ковид-19 цар тахалтай холбоотой гарсан хууль, тогтоомжоос шалтгаалан арилжааны банк дахь компанийн дансны үлдэгдэлд хүү тооцоогүй байна.	10
	Бүлэг 2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, батлагдсан зардлыг хэтрүүлэн үргүй зардал гаргасан нь компанийн засаглал үр дүнгүй байгааг харуулж байна.	11
	2.1. Компанийн батлагдсан төсвөөс үргүй зардал гаргасан байна.	11-15
	2.2. Өр төлбөрийг үнэн зөв тооцож бүртгээгүй нь санхүүгийн ажилтнуудын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.	15-17
2023 оны 9 дүгээр сар	2.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүйгээр тухайн компанид ажиллаагүй 3 хүний нийгмийн даатгалын шимтгэлд 1.4 сая төгрөг төлсөн байна.	17-18
	2.4. Компанийн удирдах болон санхүүгийн ажилтнууд олон удаа солигдсоноор санхүүгийн сахилга хариуцлага алдагдсан байна.	18-19
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 3. Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу төлөвлөсөн ч зарим худалдан авалтыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй байна.	20
	3.1. Худалдан үйл ажиллагааг хуулийн дагуу төлөвлөсөн байна.	20-21
	3.2. Зарим худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна.	21-23
	3.3. Хөрөнгө, бараа материал худалдан авахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлж, худалдан авах ажиллагааг цахимаар явуулсан байна.	23-24
	3.4. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтад ажлын комиссын акт, дүгнэлтийг үндэслэн санхүүжилт олгосон байна.	24-25
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангомьн сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Бүлэг 4. Бүртгэлд тусгаагүй, ашиглалтгүй хөрөнгө, анхан шатны баримтгүй зарцуулсан бараа материал байгаа нь бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна.	26

4.1. Үндсэн хөрөнгө, материалын тооллогыг хуулийн дагуу хийсэн байна.	26-27
4.2. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр болон бусад эх үүсвэрээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, зарим хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг буруу бүртгэсэн байна.	27-28
4.3. Бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас ашиглалтгүй хөрөнгө хадгалагдаж байна.	28-29
4.4. Эдэлгээний нөөцийн доод хязгаарын нормыг тооцохгүйгээр хөрөнгө, материал худалдан авсан байна.	29
4.5. Шатах тослох материалын зарцуулалтад тогтоосон норм, стандартыг мөрдөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан байна.	29-30
Бүлэг 5. Компанийн дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, шат шатны хяналт үр дүнгүй байна.	31
5.1. Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр дүнгүй байна	31-33
5.2. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг оновчгүй төлөвлөсөн, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийгээгүй нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.	33-35
5.3. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг 94.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.	35
5.4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хэвийн байна.	36
Дүгнэлт	37
Холбогдох байгууллагын санал	38
Аудитын газраас өгөх тайлбар	39
Зөвлөмж	40

Товчилсон үгийн тайлал:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ДДТ	Дулаан дамжуулах төв
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ЭМ	Эрүүл мэнд
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ААНБОУАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
ИТА	Инженер техникийн ажилтан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Худалдан авалт
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Нэр
Хүснэгт 1	2020-2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 2	2020-2022 оны арилжааны банкны дансанд тооцсон хүүгийн орлого
Хүснэгт 3	2020-2022 оны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 4	2020-2022 оны авлагын үлдэгдэл
Хүснэгт 5	2020-2022 оны өглөгийн үлдэгдэл
Хүснэгт 6	2020-2022 онд төлсөн татвар, шимтгэл
Хүснэгт 7	2020-2022 оны Бүтэц орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 8	Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, худалдан авах ажиллагаа
Хүснэгт 9	2020-2022 онд нэмэгдсэн хөрөнгийн дүн
Хүснэгт 10	2020-2022 онд явуулсан тендер, хөрөнгө оруулалтын худалдан авалт
Хүснэгт 11	Эд хөрөнгийн тооллого хийх тушаал
Хүснэгт 12	2020-2022 оны нэмэгдсэн хөрөнгийн дүн
Хүснэгт 13	Тендер худалдан авалтад шалгарсан харилцагч байгууллага, төсөвт өртөг
Хүснэгт 14	2020-2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 15	2020-2022 оны жил эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалга, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилго

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтуудын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орлогын бүрдүүлэлт, эх үүсвэрийг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Орлогыг бизнес төлөвлөгөөний дагуу зориулалтаар нь үр дүнтэй, үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
- Худалдан авалт, гүйцэтгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан эсэх
- Хөрөнгө, бараа материалд бүртгэлээр тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх
- Дотоод хяналт үр дүнтэй байгаа эсэх

Хамарсан хүрээ

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулан хийж гүйцэтгэв.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашигласан.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд аудитын багийг ахалж, ахлах аудитор Т.Намжил, С.Батсайхан, аудитор А.Нанжидмаа, Б.Одгэрэл, Т.Золоо, Ч.Мөнхтогтох, Т.Амармэнд нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК нь Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.31-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор баталсан дулааны эрчим хүчийг айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллагад борлуулах үнэ тарифыг мөрдөн ажилладаг.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК 2020 онд 42.4 мян.Гкал, 2021 онд 46.8 мян.Гкал, 2022 онд 53 мян.Гкал дулаан үйлдвэрлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2020 онд 38.2 мян.Гкал, 2021 онд 44.5 мян.Гкал, 2022 онд 50.4 мян.Гкал дулаан үйлдвэрлэж борлуулсан байна.

Борлуулалтын орлогыг 2020 онд 2,766.5 сая, 2021 онд 3,132.2 сая, 2022 онд 3,837.3 сая төгрөгөөр төлөвлөж батлуулсан байна. Гүйцэтгэлээр 2020 онд 2,781.9 сая, 2021 онд 3,335.5 сая, 2022 онд 3,891.6 сая, нийт 10,009.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК нь 2022 оны байдлаар 159 аж ахуй нэгж, 39 төсөвт байгууллага, 2206 айл өрхөд төвлөрсөн халаалт, улирлын шинж чанартайгаар хэрэглээний халуун усны үйлчилгээ үзүүлсэн байна. Төвлөрсөн халаалт хэрэглэгчдийн 91.8 хувийг айл өрх, 0.02 хувийг төсөвт байгууллага, 0.1 хувийг аж ахуйн нэгж байгууллага эзэлж байна.

БҮЛЭГ: 1. Аж ахуйн нэгжүүдийг дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дулаан түгээх эзлэхүүнийг зөрүүтэй тусгаснаас орлого дутуу төвлөрүүлсэн байна.

1.1. Аж ахуйн нэгжүүдийг дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дулаан түгээх эзлэхүүнийг зөрүүтэй тусгаснаас орлого дутуу төвлөрүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5 дахь заалтад "Бүх орлого" гэж заасан байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

/сая.төгрөг/

Орлогын төрөл	2020 он			2021 он			2022 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
Борлуулалтын орлого	2,650.6	2,642.2	8.4	3,032.2	3,211.5	(179.3)	3,555.4	3,609.8	(54.4)
Үйл ажиллагааны бус орлого	115.9	139.7	(23.8)	100.0	124.0	(24.0)	281.8	281.8	-
Нийт орлого	2,766.5	2,781.9	15.4	3,132.2	3,335.5	(203.3)	3,837.2	3,891.6	54.4

/Гэх сурвалж: "Улаангомын Дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Дээрх судалгаанаас харахад компанийн борлуулалтын орлого гүйцэтгэлээр 2020 онд 2,642.2 сая төгрөгөөс 2021 онд 3,211.5 сая төгрөг болж 569.3 сая төгрөгөөр буюу 21.5 хувиар, 2022 онд 3,609.8 сая төгрөг болж 2021 оноос 398.3 сая төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна.

Аудитад хамрагдсан онуудын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

Борлуулалтын орлогын гүйцэтгэл 2020 онд төсөвт байгууллагаас 1,506.6 сая, аж ахуйн нэгжээс 812.6 сая, айл өрхөөс 323.0 сая, нийт 2,642.2 сая төгрөг орж төлөвлөгөөнөөс 8.4 сая төгрөгөөр тасарсан нь тухайн онд ашиглалтад орохоор төлөвлөгдсөн аж ахуйн нэгжийн барилга нь хугацаандаа ашиглалтад ороогүйн улмаас тухайн аж ахуйн нэгжээс орох байсан борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. Харин үйл ажиллагааны бус орлого Шүүхийн шийдвэрээр орсон 23.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Борлуулалтын орлогын гүйцэтгэл 2021 онд төсөвт байгууллагаас 1,716.0 сая, аж ахуйн нэгжээс 1,044.8 сая, айл өрхөөс 450.7 сая, нийт 3,211.5 сая төгрөг орж төлөвлөгөөнөөс 179.3 сая төгрөгөөр давсан нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 464 дүгээр тогтоолоор айл өрхийн дулааны болон халуун усны үнэ тарифыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Мөн үйл ажиллагааны бус орлого Шүүхийн шийдвэрээр орсон 24.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Борлуулалтын орлогын гүйцэтгэл 2022 онд төсөвт байгууллагаас 2,263.1 сая, аж ахуйн нэгж байгууллагаас 858.6 сая, айл өрхөөс 488.1 сая, нийт 3,609.8 сая төгрөг орж, төлөвлөснөөс 54.4 сая төгрөгөөр өсөхөд шинээр хэрэглэгч нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Аудитаар "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтран 2020, 2021 онд гэрээ байгуулан дулааны эрчим хүчээр хангасан 159 аж ахуйн нэгжээс 32 аж ахуйн нэгжийг түүвэрлэн авч хэмжилт хийлээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 5.3.1-д "... Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно" гэж заасныг зөрчин түүвэрт хамрагдсан 18 аж ахуйн нэгжийн талбай гэрээнд заасан хэмжээнээс 7111.49 м.куб-аар илүү, 3 аж ахуйн нэгжийн талбай 790.18 м.куб-аар дутуу байсан бөгөөд шинээр өргөтгөл барьсан 2 аж ахуйн нэгжийн 1215.4 м.куб талбайг гэрээнд нэмж тусгахаар байна.

Дээрх хэмжилтээр гэрээний дүнгээс дулаан түгээх эзлэхүүний хэмжээ илүү байсан 18 аж ахуйн нэгжээс орох боломжтой байсан орлогыг 1 жилээр тооцож үзвэл $7111.49 \times 1430 \times 8 = 81.4$ сая төгрөгийн борлуулалтын орлого олох боломжийг алдсан байна.

Харин түүвэрт хамрагдсан 5 аж ахуйн нэгж нь тухайн цаг хугацаанд эзэнгүй байснаас шалтгаалан аудитын явцад хэмжилт хийж чадаагүй болно.

Цаашид аж ахуйн нэгжүүдийн дулаан түгээх эзлэхүүнийг нягтлан шалгаж хэмжилт хийсний үндсэн дээр гэрээг шинэчлэн байгуулахыг зөвлөмж өглөө.

1.2 Компанийн алдагдалд дүн шинжилгээ хийж татаас санхүүжилтийг төлөвлөн батлуулаагүй байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал жил бүрийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг компанийн ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлэн ажиллажээ. Ингэхдээ өмнөх оны гүйцэтгэл, тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, дараа жилийн төлөвлөгөөний төслийг харьцуулан өсөлт, бууралтыг тооцон гаргаж байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК нь 2020, 2021 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд татаас санхүүжилт төлөвлөн батлуулаагүй бөгөөд өөрийн орлогоор санхүүжиж улсын төсвөөс санхүүжилт аваагүй байна.

Харин 2022 онд 181.8 сая төгрөгийн татаас санхүүжилт авахаар төлөвлөн ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж гүйцэтгэлээр 181.8 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Мөн аймгийн төвийн айл өрхүүдэд зуны улиралд хэрэглээний халуун ус өгөх ажлын дэмжлэгт аймгийн Засаг даргын 2020 оны А/295 дугаар захирамжаар 100.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс, 2021 оны А/375 дугаар захирамжаар 100.0 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн эх үүсвэрээс, 2022 оны А/343 дугаар захирамжаар 100.0 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас тус тус санхүүжүүлсэн байна.

1.3. Ковид-19 цар тахалтай холбоотой гарсан хууль, тогтоомжоос шалтгаалан арилжааны банк дахь компанийн дансны үлдэгдэлд хүү тооцоогүй байна.

“Улаангомын Дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь 2020-2022 онд Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны 4 банкны төгрөгийн дансаар дамжуулан төлбөр тооцоог хийсэн байна. Үүнд:

Хүснэгт №2

/сая.төг/

Д/д	Банкны нэр	Валют	Дансны дугаар	Тооцогдсон хүү /сая.төгрөг/		
				2020	2021	2022
1	ХААН банк	Төгрөг	5830069529	0.4	0	0
2	Хас банк	Төгрөг	5001243118	0	0	0
3	Голомт банк	Төгрөг	6205100977	0	0	0
4	Төрийн банк	Төгрөг	162000292674	0	0	0
Нийт дүн				0.4	0	0

/Эх сурвалж: Арилжааны банкны дансны хуулга/

Дээрх данснуудаас компанийн урсгал үйл ажиллагааны орлого, зарлагын гүйлгээг өдөр тутам хийгддэг төгрөгийн 1 дансанд 2020 онд 0.4 сая төгрөгийн хүү тооцогдож хүүгийн орлого орсон байна.

Харин Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.4 дэх хэсэгт “Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй, тусгай нөхцөлтэй хадгаламжид энгийн хадгаламжийн хүү тооцох бөгөөд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д заасны дагуу Монгол банкнаас зөвшөөрөл олгосон болон 4.4-т зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно” гэж заасны дагуу 2021, 2022 онуудад хүүгийн орлого тооцоогүй байна.

БҮЛЭГ: 2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, батлагдсан зардлыг хэтрүүлэн үргүй зардал гаргасан нь компанийн засаглал үр дүнгүй байгааг харуулж байна.

2.1. Компанийн батлагдсан төсвөөс үргүй зардал гаргасан байна.

“Улаангомьын дулааны 2 дугаар станц” ТӨХК-ийн 2020-2022 оны зардал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №3

/сая.төг/

Зардлын төрөл	2020 он			2021 он			2022 он		
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /-/ хэмнэлт/-	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /-/ хэмнэлт/-	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /-/ хэмнэлт/-
Үйл ажиллагааны зардал	3,041.4	3,239.9	-198.5	3,321.4	3,504.4	-183.0	4,512.6	4,817.8	-305.2
Эрчим хүчний төлбөр									
Нийт	3,041.4	3,239.9	-198.5	3,321.4	3,504.4	-183.0	4,512.6	4,817.8	-305.2

/Эх сурвалж: “Улаангомьын дулааны 2 дугаар станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Судалгаанаас харахад нийт зардлын дүн 2020 онд 198.5 сая, 2021 онд 183.0 сая, 2022 онд 305.2 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

ТУЗ-өөр батлагдсан зардал 2020 онд 3,041.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 3,239.9 сая төгрөгийн зардал гарч 198.5 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Нийт зардлын 13.6 хувь буюу 440.9 сая төгрөгийг түлшний зардал, 26.3 хувь буюу 851.6 сая төгрөгийг цалингийн зардал, 3.8 хувь буюу 123.5 сая төгрөгийг НДШ-ийн зардал, 22.1 хувь буюу 715.0 сая төгрөгийг элэгдлийн зардал, 11.0 хувь буюу 357.2 сая төгрөгийг цахилгааны зардал, 3.5 хувь буюу 113.1 сая төгрөгийг усны зардал, 3.6 хувь буюу 115.1 сая төгрөгийг ажиллагсдын нийгмийн зардал, 4.9 хувь буюу 159.5 сая төгрөгийг үйл ажиллагааны бусад зардал, 11.2 хувь буюу 363.9 сая төгрөгийг 24 нэр төрлийн зардал эзэлж байна.

Зардал хэтрэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Үйл ажиллагааны бус зардал нь шүүхийн шийдвэрийн дагуу 558.3 сая төгрөгийг “Хар тарвагатай” ХХК-д төлсөн,
- Тайлант оны дундуур бензин, шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор нүүрс тээврийн зардал өссөн.

ТУЗ-өөр батлагдсан зардал 2021 онд 3,321.4 сая, гүйцэтгэлээр 3,504.4 сая төгрөгийн зардал гарч 183.0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Нийт зардлын 21.4 хувь буюу 1,032.5 сая төгрөгийг түлшний зардал, 27.1 хувь буюу 1,307.9 сая төгрөгийг цалингийн зардал, 6 хувь буюу 336.4 сая төгрөгийг НДШ-ийн зардал, 16.2 хувь буюу 783.4 сая төгрөгийг элэгдлийн зардал, 10.3 хувь буюу 499.1 сая төгрөгийг цахилгааны зардал, 2.5 хувь буюу 122.7 сая төгрөгийг усны зардал, 2.8 хувь буюу 138.0 сая төгрөгийг ажиллагсдын нийгмийн зардал, 12.4 хувь буюу 597.8 сая төгрөгийг бусад зардал эзэлж байна.

Зардал хэтрэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийн дагуу 155.0 сая төгрөгийн нүүрсний үнэ төлсөн,
- ТУЗ-өөр баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 1 ажлыг гүйцэтгэсэн,

- Тайлант онд төлөвлөсөн нүүрсний хэрэглээ өссөнөөс шалтгаалан түлш шатах тослох материалын зардал өссөн,
- Компанийн шанагатай ачигч ковш эвдэрч түрээсийн гэрээ байгуулан техник ажиллуулсан,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар 4 ДДТ шинээр ашиглалтад орж айл өрх нэмэгдсэнээс усны зардал өссөн.

ТУЗ-өөр батлагдсан зардал 2022 онд 4,512.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 4,817.8 сая төгрөгийн зардал гарч 305.2 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Нийт зардлын 21.4 хувь буюу 1,032.5 сая төгрөгийг түлшний зардал, 27.1 хувь буюу 1,307.9 сая төгрөгийг цалингийн зардал, 6 хувь буюу 336.4 сая төгрөгийг НДШ-ийн зардал, 16.2 хувь буюу 783.4 сая төгрөгийг элэгдлийн зардал, 10.3 хувь буюу 499.1 сая төгрөгийг цахилгааны зардал, 2.5 хувь буюу 122.7 сая төгрөгийг усны зардал, 2.8 хувь буюу 138.0 сая төгрөгийг ажиллагсдын нийгмийн зардал, 12.4 хувь буюу 597.8 сая төгрөгийг бусад зардал эзэлж байна.

Зардал хэтрэхэд дараах хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийн дагуу 63.5 сая төгрөгийн нүүрсний үнэ төлсөн,
- Компанийн шанагатай ачигч ковш, үнс тээврийн автомашин нь эвдэрч сэлбэг хэрэгсэл ихээр авсан болон түрээсийн гэрээ байгуулан техник ажиллуулсан,
- Эрчим хүчний 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотойгоор 17.0 сая төгрөгийн албан томилолтын зардал гаргасан,
- Тайлант онд ажилтнуудын цалин нэмэгдсэн,
- Төлөвлөгөөнд тусгагдаагүй үргүй зардал гаргасан,
- ТУЗ-өөр баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 1 ажлыг гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан онуудад компани ТУЗ-өөр батлагдсан төсөвт зардлыг үргүй зарцуулсан дараах зөрчлүүд байна. Үүнд:

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК нь "Хотгор шанага" ХХК-тай гэрээ байгуулж 2014-2018 онд нүүрс худалдан авах явцад пүүний зөрүүтэй холбоотой маргаан гарч хоёр тал тухайн үед тооцоо нийлж шийдвэрлэж чадаагүй байна.

Уг асуудлаар бэлтгэн нийлүүлэгч "Хотгор шанага" ХХК-ийн зүгээс 2019 онд Увс аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Маргаан шүүхийн шатанд хянагдаж байх явцад тухайн үеийн "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн захирал төлөх үндэслэл байхгүй талаар тайлбар гаргаж шүүхэд хүргүүлсэн боловч компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлагын талаар харилцан тохиролцож гэрээний гүйцэтгээгүй үүрэг 174.9 сая, алданги 43.0 сая төгрөгийг төлөхөөр зөвшөөрч эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

Увс аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 452 дугаар захирамж гарч "Хотгор шанага" ХХК-д 2021 онд 155.0 сая, 2022 онд 63.5 сая, нийт 218.5 сая төгрөг төлснөөс алданги 43.0 сая, шүүхийн шатанд эвлэрлийн гэрээ байгуулж пүүний зөрүүнээс үүссэн 59.8 сая, тэмдэгтийн хураамж 0.6 сая, нийт 103.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Түүнчлэн Увс аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 621 дүгээр шийдвэрээр "Хартарвагатай" хувьцаат компанид 555.2 сая төгрөг төлснөөс алданги 112.5 сая, тэмдэгтийн хураамж 2.9 сая нийт 115.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Тухайн үед ажиллаж байсан компанийн хуулийн зөвлөхөд 2020 онд Баян-Өлгий аймагт ажилласан албан томилолтын зардал гэж Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын тамга дарагдсан томилолтын хуудас, Ховд аймгийн буудлын баримтаар нийт 0.25 сая төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "Үнэн, зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоолоо.

Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6 дахь хэсэгт "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчин компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/41 дүгээр тушаалаар ажилчдын зугаалгад гэж 2.6 сая, 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохиолдуулан эмэгтэй ажилтнуудыг хүлээн авахад 0.5 сая, 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар аймгийн ГХБХБГ-ын зохион байгуулсан гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээний бооцоо 0.2 сая, 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар гар бөмбөгийн холбооны цом тэмцээнд оролцоход 0.6 сая, нийт 3.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана", 15.2.3 дахь заалтад "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасан байхад Улаангомын дулааны хоёрдугаар станц ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2022 оны бизнес төлөвлөгөө батлах тухай тогтоолд компанийн албан томилолтын нийт зардал 10.9 сая төгрөг байхаар баталсан байхад Монгол улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан "Эрчим хүчний салбарын спортын их наадам"-д оролцоход гэж 20 хүнд 6 өдрийн томилолтоор тооцон 17.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Цаашид хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, батлагдсан зардлыг хэтрүүлэхгүй байх зөвлөмж өглөө.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн №22-01/22 дугаар шалгалтын удирдамжийн дагуу албан томилолтоор ажилласан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хяналтын ажилтны буудлын үнэ 0.3 сая, хоолны үнэ 0.2 сая, нийт 0.5 сая төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр компаниас төлсөн байсныг аудитын явцад тухайн ажилтнаар төлүүлж компанийн дансанд төвлөрүүлэн зөрчлийг арилгасан.

Хувь иргэнээр 2022 оны 12 сард 2 удаагийн нүүрс тээвэр хийлгэхээр 300 л шатахуун өгсөн ч нэг удаагийн тээвэр хийлгээгүй, тооцоо нийлээгүй байсанд

шатахууны үнэ, тээврийн хөлсний зөрүү болох 0.4 сая төгрөгийг аудитын явцад төлүүлж компанийн дансанд төвлөрүүлж зөрчлийг арилгасан.

Монгол улсад орчин цагийн эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын хурлыг зохион байгуулах тухай Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 4/4496 дугаар албан бичгийн дагуу 3 ажилтан Улаанбаатар хотод 12 дугаар сарын 8-ны өдөр очсон бөгөөд тухайн ойн арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшилж Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн в/4849 дүгээр ойн баярын хурлын арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшилсон тухай албан бичиг гарах хүртэл хотод хүлээсэн байна. Энэхүү хугацаанд тухайн 3 ажилтанд нийт 4.7 сая төгрөгийн албан томилолтын зардал гарсан ч 2022 онд ойн баярын хурлын арга хэмжээ болоогүй байна.

Цаашид төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж үргүй зардал гаргахгүй байх зөвлөмж өглөө.

"АБЦТ" ХХК-д материалын үнэ гэж 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 4.5 сая төгрөгийг шилжүүлж санхүүгийн тайланд урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байсан. Аудитын явцад хүлээн аваагүй материалын үнэ 4.5 сая төгрөгийг төлүүлж "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн дансанд төвлөрүүлж зөрчлийг арилгуулсан.

Компанид 2016 онд ашиглалтад орсон 19.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, 7 жил ашигласан 5.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үнс ачих зориулалттай Кантер машинд 2022 оны 5 дугаар сард мотор болон бусад сэлбэг засварт 16.1 сая, Улаанбаатарт очиж сэлбэг авсан жолоочийн томилолтын зардалд 0.5 сая, нийт 16.6 сая төгрөгийн зардал гаргасан байна. Гэтэл тухайн автомашин дахин эвдэрч 2022 оны 10-12 сард үнс ачилт хийлгэсэн ажлын хөлс гэж хувь хүмүүст 10.6 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн байна. Мөн 2023 онд тухайн автомашины сэлбэг, засварт гэж 5.6 сая төгрөг дахин зарцуулсан байна.

Цаашид компанийн Өмч хамгаалах зөвлөл нь эвдэрсэн, засаж сэлбэх шаардлагатай техник тоног төхөөрөмжүүдэд дүгнэлт гаргаж байх, мөн ашиглалтын шаардлага хангахгүй, засвар үйлчилгээ хийсэн ч ажил гүйцэтгэх боломжгүй техник хэрэгсэлд үргүй зардал гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Эрчим хүчний сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/2322 дугаар бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлаар 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Увс аймагт ирж ажилласан байна. Удирдамжид томилолт, шатахууны зардлыг компанийн ТУЗ-ийн зардлаас гаргахаар заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн ирсэн машин түрээсийн хөлсөнд 1.1 сая төгрөг зарцуулсанд гэрээ байгуулаагүй аман тохиролцоогоор төлбөрийг гүйцэтгэсэн байна. Цаашид бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд гэрээ байгуулж төлбөр тооцоог хяналттайгаар хийж байх зөвлөмж өглөө.

"Эрчим хүчний үндэсний төв" ТӨХК-ийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2022 оны 12 сард цахилгааны инженерийг "0.4 кВ-ын асинхрон цахилгаан хөдөлгүүрийн статорын ороомгийн хөндийрүүлэг, ороомгийн" /ахисан шатны/ 20 өдрийн сургалтад хамруулж 3.0 сая төгрөгийн томилолт, 0.9 сая төгрөгийн сургалтын төлбөр төлсөн байна. Гэтэл тухайн ажилтан нь 2023 оны 7 сард ажлаас гарсан бөгөөд сургалтад суралцуулахдаа гэрээ байгуулаагүйгээс компанийн хувьд үргүй зардал болсон байна.

Цаашид компанийн төсвийн зардлаар нарийн мэргэжлийн урт хугацааны сургалтад хамрагдах ажилтантай гэрээ байгуулж сургалтын үр дүнг ажлын байранд нэвтрүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Машин механизмыг түрээсээр ажиллуулах тухай 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хувь иргэнтэй шууд гэрээ байгуулсан байх бөгөөд гэрээний 1.1-д “нэг мото цагийн хөлс 180000 төгрөг байх”-аар тусгаж 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл ажил гүйцэтгүүлсэн байна. Гэтэл 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс ковш түрээслүүлэх үнийн саналыг 2 компаниас авч бага үнийн саналаар 1 мото цагийн хөлсийг 97000 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна. Ингэснээр хямд үнээр гэрээ байгуулах боломж алдагдаж үргүй зардал гаргасныг харуулж байна.

Цаашид компанийн төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулах зөвлөмж өглөө.

2.2. Өр төлбөрийг үнэн зөв тооцож бүртгээгүй нь санхүүгийн ажилтнуудын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2020-2022 оны авлагын үлдэгдэл дараах байдалтай байна.

Хүснэгт №4

/сая.төг/

Авлагын төрөл	2020 оны эцэст		2021 оны эцэст		2022 оны эцэст	
	Богино хугацаат	Урт хугацаат	Богино хугацаат	Урт хугацаат	Богино хугацаат	Урт хугацаат
Айл өрх	84.8		48.9		147.0	
ААН	90.7		79.8		112.9	
Төсөвт байгууллага	-		1.7		6.1	
Монгол улсын ЗГ	86.6		171.5			
Дулааны авлагын дүн	262.1	-	301.9	-	266.0	
Татварын авлагын дүн			0.0			
Ажилчдаас авах	0.2		0.3		26.1	
Бусад авлага	5.5		5.4		1.0	
Бусад авлагын дүн	5.7	-	5.7	-	27.1	
Нийт дүн	267.8	-	307.6	-	293.1	

/Эх сурвалж: “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Дээрх судалгаанаас харахад авлагын дүн 2020 онд 267.8 сая төгрөг байснаас 2021 онд 307.6 сая төгрөг болж 39.8 сая төгрөг буюу 12.9 хувиар өсөхөд айл өрхийн дулааны төлбөрийг төрөөс хариуцах шийдвэр гарснаас шалтгаалан Засгийн газраас авах 171.5 сая төгрөгийн авлага үүссэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Харин 2022 оны авлага 293.1 сая төгрөг болж 2021 оноос 14.5 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна.

Эрчим хүчний сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/2322 дугаар бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг зохион байгуулах, тогтоол гаргах ажлаар 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Увс аймагт ирж ажилласан байх бөгөөд удирдамжид томилолт, шатахууны зардлыг компанийн ТУЗ-ийн зардлаас гаргахаар заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дансанд 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 2.1 сая төгрөг шилжүүлснээс

зарцуулалтын баримтыг ирүүлээгүй 1.4 сая төгрөгийг компанийн дансанд хувь хүнээс авах авлагаар тусгажээ.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 оны өглөгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Хүснэгт №5

/сая.төг/

Өглөгийн төрөл	2020 оны эцэст		2021 оны эцэст		2022 оны эцэст	
	Богино хугацаат	Урт хугацаат	Богино хугацаат	Урт хугацаат	Богино хугацаат	Урт хугацаат
Хар тарвагатай	47.2		230.9		638.2	
Хотгор ХХК	218.5		63.5			
Цахилгаан түгээх сүлжээ ХХК	185.0		174.7		153.0	
Чандмань Увс ХХК					16.2	
Ундарга Увс ХХК					69.5	
Нүүрсний тээврийн хөлс	34.0		11.9		12.1	
Дулааны өглөгийн дүн	484.7	-	481.0	-	889.0	
НӨАТ	58.2		21.8		2.1	
ХХОАТ	6.3		0.2		18.0	
ЭМ, НДШ	23.7		6.7		30.8	
Бусад татвар хураамж			1.2			
Татварын өглөгийн дүн	88.2	-	29.9	-	50.9	
Албан байгууллага	9.0				1.6	
Цалингийн	1.4		1.8		2.4	
Урьдчилж орсон орлого	14.1		14.6		9.2	
Бэлтгэн нийлүүлэгчид	63.1		12.4			
Бусад			52.0			
Бусад өглөгийн дүн	87.6	-	80.8	-	13.2	
Нийт дүн	660.5	-	591.7	-	953.1	
Богино хугацаат зээлийн өр-ДҮТ	370.1					
Өглөгийн дүн	1,030.6	-	591.7	-	953.1	-

/Эх сурвалж: "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Дээрх судалгаанаас харахад богино хугацаат өр төлбөрийн дүн 2020 онд 1,030.6 сая төгрөг байснаас 2021 онд 591.7 сая төгрөг болж 438.9 сая төгрөг буюу 42.6 хувиар буурсан, 2022 онд 953.1 сая төгрөг болж 2021 оноос 361.4 сая төгрөгөөр буюу 37.9 хувиар өссөн байна. Өр төлбөрийн өсөлт, бууралтад дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

- ✓ 2020 оны өглөгийн үлдэгдэл 1,030.6 сая төгрөг байснаас 2021 онд 591.7 сая төгрөг болж 438.9 сая төгрөгөөр буурсан нь Диспетчерийн үндэсний төвд өгөх 370.1 сая, нүүрс тээврийн зардлын өглөг 22.1 сая, НДШ-ийн өглөг 17.0 сая, бусад өглөг 29.7 сая төгрөгийг тус тус төлж барагдуулснаас шалтгаалсан байна.
- ✓ 2021 оны өглөгийн үлдэгдэл 591.7 сая төгрөг байснаас 2022 онд 953.1 сая төгрөг болж 361.4 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний өр 343.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь заалтад "Бүх өр төлбөр" гэж заасныг тус тус зөрчин 2022 оны санхүүгийн тайланд зарим өр төлбөрийг илүү, дутуу бүртгэсэн байна. Үүнд:

- Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж хийгдсэн ДДТ-ыг автоматжуулах, хяналт удирдлагын системээр тоноглох 139.2 сая төгрөгийн ажлыг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч 12 дугаар сарын 07-ны өдөр 69.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд үлдэх 70.2 сая төгрөгийн өглөгийг 2022 оны санхүүгийн тайланд тусгахгүйгээр 2023 онд төлсөн,
- 2022 онд үүссэн 2 иргэнд олгох нийт 4.7 сая төгрөгийн тээврийн хөлсний өрийг санхүүгийн тайланд тусгахгүйгээр 2023 онд олгосон,
- 2022 оны санхүүгийн тайланд "Увс ЦТС" ХХК-д 559.7 сая төгрөг шилжүүлснийг 552.5 сая төгрөгөөр бүртгэж 7.3 сая, "Чандмань Увс" ХХК-д 164.9 сая төгрөг шилжүүлснийг 159.4 сая төгрөгөөр бүртгэж 5.5 сая, "Ундарга Увс" ХХК-д 136.4 сая төгрөг шилжүүлснийг 134.7 сая төгрөгөөр бүртгэж 1.7 сая, нийт 14.5 сая төгрөгөөр өр төлбөрийг илүү илэрхийлсэн,
- Машин механизмыг түрээсээр ажиллуулах тухай 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хувь иргэнтэй байгуулсан гэрээний дагуу төлбөр төлөхдөө 2022 оны санхүүгийн тайланд өр төлбөр тусгахгүйгээр 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 5.3 сая, 2 дугаар сарын 17-ны өдөр 3.0 сая, 5 дугаар сарын 16-ны өдөр 7.0 сая, нийт 15.3 сая төгрөгийг урд оны өр нэрээр төлсөн.

Цаашид санхүүгийн тайланд өр төлбөрийг үнэн зөв илэрхийлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх зөвлөмж өглөө.

2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүйгээр тухайн компанид ажиллаагүй 3 хүний нийгмийн даатгалын шимтгэлд 1.4 сая төгрөг төлсөн байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 онд төлсөн татвар, нийгмийн даатгалын шимтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт №6		/сая.төг/					
Д/д	Татвар, шимтгэлийн нэр төрөл	2020 оны эцэст		2021 оны эцэст		2022 оны эцэст	
		Хувь хэмжээ	Мөнгөн дүн	Хувь хэмжээ	Мөнгөн дүн	Хувь хэмжээ	Мөнгөн дүн
1	ААНБОАТ		0		0		0
2	ХХОАТ	9	66	9.3	71.5	10.6	93
3	НӨАТ	49.4	356.7	49.6	380.6	48.4	420.8
4	ҮХХ-ийн татвар	1.5	10.5	1.4	10.5	1.2	10.5
5	Газар, усны төлбөр	0.7	4.8	0.7	4.8	0.5	4.8
6	ЭМ, НДШ	39.1	281.6	38.8	297.5	39.1	339.8
7	Бусад татвар, хураамж	0.3	1.9	0.2	1.9	0.2	1.9
	ДҮН	100	721.5	100	766.8	100	868.9

/Эх сурвалж: "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Дээрх судалгаанаас харахад татвар, шимтгэлийн дүн 2020 онд 721.5 сая төгрөг байснаас 2021 онд 766.8 сая төгрөг болж 45.3 сая төгрөг буюу 6.2 хувиар, 2022 онд 868.9 сая төгрөг болж 2021 оноос 102.1 сая төгрөгөөр буюу 13.3 хувиар

тус тус өссөн байна. Дээрх өсөлтөд НӨАТ, ЭМ, НДШ-ийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- НӨАТ 2021 онд 534.5 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар, 2022 онд 1,114.3 сая төгрөг буюу 42 хувиар өссөн байна.
- ЭМ, НДШ 2021 онд 44.1 сая төгрөгөөр буюу 10.4 хувиар, 2022 онд 59.6 сая төгрөг буюу 12.7 хувиар өссөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2 дахь заалтад "Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох" Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.2-д "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх", "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн дүрмийн 10.11.8 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх" гэж заасныг тус тус зөрчин спортын уралдаан тэмцээнд оролцуулах зорилгоор 3 тамирчны нийгмийн даатгалын шимтгэлд 1.4 сая, 2022 оны 8 дугаар сард 1 иргэнд тушаал шийдвэргүйгээр цалинд 0.5 сая, нийт 1.9 сая төгрөгийн үргүй зардал гаргасанд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2.4. Компанийн удирдах болон санхүүгийн ажилтнууд олон удаа солигдсоноор санхүүгийн сахилга хариуцлага алдагдсан байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020, 2021 оны "Бизнес төлөвлөгөө батлах тухай" тогтоолоор компанийн орон тооны дээд хязгаарыг баталж, 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэл баталсан байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн бүтэц, орон тоо 2020-2022 онд дараах байдалтай байна.

Хүснэгт №7

Хэлтэс, нэгж	2020 он			2021 он			2022 он		
	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт
Удирдлага	3	3	0	3	2	1	3	3	
ИТА	66	66	0	66	66	0	63	63	
Борлуулалт Захиргаа	24	22	2	24	24	0	27	27	
Дүн	93	91	2	93	92	1	93	93	0

/Эх сурвалж: "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн тушаал, шийдвэр/

Аудитад хамрагдсан 2020 онд 2 орон тоо дутуу, 2021 онд 1 орон тоо дутуу, 2022 онд компани батлагдсан бүтэц, орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Аудитад хамрагдсан 2020-2022 онд компанийн гүйцэтгэх захирал 4 удаа, ерөнхий нягтлан бодогч 3 удаа солигдсон байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн үйлдвэрчний эвлэлийн хорооноос 2022 онд ажилтнуудын цалин, нэмэгдэлтэй холбоотой асуудлыг шалгуулах тухай өргөдөл, гомдлыг Эрчим хүчний яаманд хүргүүлсэн байна.

Эрчим хүчний сайдын баталсан Хяналт шалгалтын удирдамжийн дагуу Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын ажлын хэсэг хяналт шалгалт хийж 6 дүгнэлт гаргаж, 5 саналыг “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-д ирүүлжээ.

Тухайн цалин, нэмэгдлийг буруу тооцож олгож, ажилтнуудаас буцаан суутгасан гэх асуудлыг компанийн ажилтнуудын төлөөлөл Увс аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан нь эцэслэн шийдэгдээгүй хянагдаж байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 10.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлага барагдуулах зөвлөмж өгснөөс 2.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байсанд зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлээ.

Компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Б.Алтангэрэл нь 2022 онд эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал болон ээлжийн амралтын олговорт нийт 4.2 сая төгрөгийг авсан нь ТУЗ-өөс “Улаангомын сумын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 4.2 дахь заалтад “Хувьцаа эзэмшигчийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам”-аар гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг дүгнэх бөгөөд ажлын үр дүнгийн урамшуулал олгох эсэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн шийдвэрлэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Цаашид үр дүнгийн урамшуулал, ээлжийн амралтыг хууль журамд заасны дагуу үндэслэх шийдвэртэйгээр олгож байх зөвлөмж өглөө.

Мөн тухайн үед мөрдөгдөж байсан Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт “Ажилтны цалин хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно”, 63.1.1 дэх заалтад “Ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан, 63.1.2 дахь заалтад “Хууль тогтоомжид заасан бусад тохиолдол” гэж заасан байхад 2020, 2021 онд хууль тогтоомжид заагдаагүй албан утасны төлбөр, ажилтнуудын нийлэмж гэх мэт төлбөр тооцооны суутгалыг хийсэн байна.

Цаашид цалингийн зардлаас хууль тогтоомжийн хүрээнд суутгал хийж байхыг зөвлөлөө.

БҮЛЭГ: 3. Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу төлөвлөсөн ч зарим худалдан авалтыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй байна.

3.1. Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу төлөвлөсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ", Сангийн сайдын тухайн үед мөрдөгдөж байсан "Журам шинэчлэн батлах тухай" 2017 оны 363 дугаар тушаал, "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2018 оны 281 дүгээр тушаал, одоо мөрдөгдөж байгаа Сангийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 102 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-д заасны дагуу тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүр ТУЗ-өөр батлуулжээ.

Төлөвлөгөөнд хөрөнгө оруулалт, их засвар, нүүрс тээвэр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал, бараа материалын худалдан авалтад зориулан тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан босго үнийг баримтлан төлөвлөсөн байна. Үүнд:

- ТУЗ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалт 4, харьцуулалтын аргаар 5, шууд гэрээ 1, шууд худалдан авалт 34, нийт 44 нэр төрлийн 1,016.2 сая төгрөгийн ажил тусгагджээ.
- ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалт 2, харьцуулалтын аргаар 9, шууд худалдан авалт 20, нийт 31 нэр төрлийн 781.1 сая төгрөгийн ажил тусгагджээ. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор босго үнэ шинэчлэн баталсантай холбоотойгоор ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 18 дугаар тогтоолоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна. Шинэчлэн баталсан төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалт 2, харьцуулалтын аргаар 1, шууд худалдан авалт 26, нийт 29 нэр төрлийн 781.1 сая төгрөгийн ажил тусгагджээ. Ингэхдээ 4.0 сая төгрөгийн 2 ажлыг хасаж 1 ажлын төсөвт өртгийг 4.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.
- ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн дэмжээд 01 дүгээр тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад дараах үүрэг чиглэлүүдийг өгсөн байна. Үүнд:
 - ❖ Компанийн 2022 оны худалдан авах төлөвлөгөөг Сангийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 102 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.4 дэх хэсэгт заасны дагуу баталж холбогдох газруудад хүргүүлэх.

- ❖ Худалдан авах төлөвлөгөөний хугацааг дахин нягтлах.
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох дүрэм журмын дагуу батлагдсан төсөвт багтаан шуурхай зохион байгуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр ТУЗ-д тайлагнах.

ТУЗ-өөс өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг компанийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан байна. Төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалт 4, харьцуулалтын аргаар 6, шууд худалдан авалт 19, нийт 1,331.2 сая төгрөгийн 29 нэр төрлийн ажил тусгагджээ.

3.2. Зарим худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна.

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, ТУЗ-ийн баталсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулсан байна.

Хүснэгт №8

/сая.төг/

	Нэр төрөл	Төсөв сая.төг	Тендер зарласан огноо	Худалдан авах ажиллагааны төрөл	Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд
2020 он					
1	Нүүрс тээврийн зардал	455.0	2020.01.31 2020.03.03 2020.10.13	НТШ	"Түмэнд нээлттэй хязгаарынхан"ХХК
3	Шатахуун бензин шатах тослох материал нийлүүлэх	31.2	2020.02.03	НТШ	Баялаг Увс ХХК
4	Ажлын хувцас,/өвөл,зун/	15.4	2020.09.30	ХА	Өнөрбаянхайрхан ХХК
5	Ажлын гутал/өвөл,зун/	16.6	2020.09.30	ХА	Эко гутал ХХК
2021 он					
1	Түлшний зардал	439.7	2021.08.02	НТШ	"Түмэнд нээлттэй хязгаарынхан"ХХК
2	Цахилгаан нөөц эх үүсвэр 400кВа-1ш	100.0	2021.09.02 2021.10.07	НТШ	"Увс дүүрэн арвижих"ХХК
3	Шатахуун бензин нийлүүлэх	45.6	2021.03.18	ХА	"НИК" ХХК
4	Хүнсний бүтээгдэхүүн /хоолны мах/	19.5	2021.03.16 2021.04.06 2021.04.13	ХА	Харьцуулалтын аргаар 3 удаа тендер зарлаад оролцогч байхгүй тул зах зээлээс шууд худалдан авалт хийсэн
5	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл /маск, бээлий, каск, чихэвч, гар чийдэн/	11.4	2021.04.05	ХА	Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор босго үнэ шинэчлэгдсэн.
6	Машины сэлбэг хэрэгсэл	10.6	2021.03.23 2021.04.07	ХА	
2022 он					
1	Шатахуун ,бензин нийлүүлэх	312.0	2022.02.10	НТШ	Ундарга Увс ХХК

2	Нүүрс тээвэрлэх машин /Даац 50тн/ авах	240.0	2022.02.15 2022.06.24	НТШ	Чандманьтуул ХХК Ньюпрестиж ХХК
3	ДДТ-дийг автоматжуулах, хяналт удирдлагын системээр тоноглох	139.2	2022.02.15	НТШ	Сүмбэр инженеринг ХХК
4	Зуух №3-ын уутат фильтрийн уутыг шинэчлэх	72.0	2022.02.12 2022.05.11	НТШ	Скайблю Фортон ХХК
5	Нүүрс тээвэр	99.3	2022.09.30 2022.11.02	НТШ	0
6	Зуух №3-ын утаа сорогч, үлээх салхилуурын цахилгаан хөдөлгүүрт давтамж хувиргуур суурилуулах. /90кВт, 55кВт/ авах	30.8	022.03.04	ХА	Монхорус интернэшнл ХХК
7	Хүнсний бүтээгдэхүүн /хоолны мах /	26.0	2022.02.16 2022.04.13 2022.05.09	ХА	Жамцэг ХХК
8	ХХ-ийн гутал /өвөл, зун/	22.1	2022.02.16	ХА	Жамцэг ХХК
9	Машины дугуйнууд худалдаж авах	21.6	2022.02.17 2022.04.13 2022.05.11 2022.05.23 2022.05.30	ХА	Чанартай дугуй ХХК
10	ХХ-ийн хувцас /өвөл, зун/	20.7	2022.02.16	ХА	Өнөрбаянхайрхан ХХК
11	Цахилгаан үүсгүүр 100квт, 50квт	21.5	2022.02.23 2022.04.07	ХА	0

/Эх сурвалж: tender.gov.mn/

Тухайн үед үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан шууд худалдан авалт хийсэн 4, худалдан авалт хийгдээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:

- Нүүрс тээврийн тендерийг 2020 онд нээлттэй тендер шалгаруулалтаар 3 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул “Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна. Хүнсний бүтээгдэхүүн /хоолны мах/ худалдан авах тендерийг 2021 онд харьцуулалтын аргаар 3 удаа тендер зарлаад оролцогч байхгүй тул зах зээлээс шууд худалдан авалт хийсэн байна.
- Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл /маск, бээлий, каск, чихэвч, гар чийдэн/ 11.4 сая, Машины сэлбэг хэрэгсэл 10.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг 2021 онд харьцуулалтын аргаар цахимаар зарласан ч оролцогч ирээгүй байна. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор босго үнэ шинэчлэн баталсантай холбоотойгоор ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 18 дугаар тогтоолоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан тул дээрх 2 барааг шууд худалдан авсан байна.
- “Нүүрс тээвэрлэх машин худалдан авах” ажлын тендерийг 2022 онд цахимаар зарлаж Чандманьтуул ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч техникийн тодорхойлолтод нийцээгүй машин ирүүлснийг шаардлага хангахгүй гэсэн шалтгаанаар буцааж дахин тендер зарласан байна. 2 дахь удаагийн тендерт Ньюпрестиж ХХК шалгарсан ч автомашин нийлүүлээгүй тул тус худалдан авалт хийгдээгүй байна.

ТУЗ-өөр батлуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2021 онд “Дулаан дамжуулах төвүүдийг камержуулах” 5.0 сая, 2022 онд “Станцын аваарын дизелийн байр барих” 14.0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг тус тус гүйцэтгүүлж санхүүжилт олгосон.

Мөн нүүрс тээврийн 2021 оны тендерт шалгараагүй 24 иргэн, 1 аж ахуйн нэгжээр 4785.5 тонн нүүрс тээвэрлүүлж 64.6 сая, 2022 оны 3 дугаар сараас нүүрс тээврийг хувь жолооч нараар гүйцэтгүүлсэн байх бөгөөд нийт 16,270.8 тонн нүүрс

тээвэрлүүлж 221.4 сая төгрөгийн тээврийн хөлсийг ямар нэг гэрээ байгуулахгүйгээр тухай бүрийн гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй ажлыг санхүүжүүлэхгүй байх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тендерт шалгарсан, гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, иргэнээр нүүрс тээвэрлүүлж байх зөвлөмж өглөө.

Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан босго үнийг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн өөрийн ашиглаж байсан ковш эвдэрсэн гэсэн шалтгаанаар 2021 онд ковш түрээсийн зардалд 35.1 сая, 2022 онд 35.8 сая нийт 70.9 сая төгрөгийг зарцуулсан,
- Тендер зарлахгүйгээр 2020 онд Хотгор ХХК, Хар тарвагатай ХХК-аас 91.8 сая, 2021 онд Хар тарвагатай ХХК-аас 300.0 сая, 2022 онд Хар тарвагатай ХХК-аас 382.0 сая, нийт 773.8 сая төгрөгөөр нүүрс худалдан авсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ”, 27.1.1 дэх заалтад “энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага”, 27.1.2 дахь заалтад “техникийн тодорхойлолт”, 27.1.3 дахь заалтад “тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага”, 27.3 дахь хэсэгт “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ”, 27.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэж заасныг зөрчин тендерийн бичиг баримтад тусгай зөвшөөрөл шаардана гэж заасан байхад “Цахилгааны нөөц эх үүсвэр 400 кВа” нийлүүлэх тендерийг 2021 онд цахимаар 2 удаа зарлаж тусгай зөвшөөрөлгүй “Увс дүүрэн арвижих” ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулан тус ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Цаашид тендерийн бичиг баримтад тусгасан шаардлага хангасан этгээдийг шалгаруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3. Хөрөнгө, бараа материал худалдан авахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлж, худалдан авах ажиллагааг цахимаар явуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасан байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2020-2022 онд нэмэгдсэн хөрөнгө дараах байдалтай байна.

Хүснэгт №9

/сая.төг/

№	Эх үүсвэр	2020	2021	2022	Нийт
1	Шинээр худалдан авсан	34.4	44.6	153.5	232.5
2	Харьяа яамнаас	78.9		34.6	113.5
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар		816.1		816.1
Нийт		113.3	860.7	188.1	1,162.1

/Эх сурвалж: “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Худалдан авах ажиллагааг явуулахдаа зарим төсөл, арга хэмжээнд оролцогч ирээгүй, шаардлага хангахгүй зэрэг шалтгааны улмаас зарим тендерийг цахимаар 2-5 удаа зарласан байна.

Нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын арга хэрэглэсэн үед төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим сайтад байршуулж, тендерийн урилгыг tender.gov.mn, Өглөөний сонин, Увсын өнгө сонин болон орон нутгийн 2 телевизээр олон нийтэд мэдээлсэн байна. Үүнд: 2020 онд давхардсан тоогоор 6 цахим тендер зарласнаас нээлттэй тендер шалгаруулалтаар 4, харьцуулалтын аргаар 2 удаа, 2021 онд давхардсан тоогоор 10 цахим тендер зарласнаас нээлттэй тендер шалгаруулалтаар 3, харьцуулалтын аргаар 7 удаа, 2022 онд давхардсан тоогоор 21 цахим тендер зарласнаас нээлттэй тендер шалгаруулалтаар 8, харьцуулалтын аргаар 13 удаа тус тус зарлажээ.

3.4. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах комиссын акт, дүгнэлтийг үндэслэн санхүүжилт олгосон байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2020-2022 онд зохион байгуулсан тендер, худалдан авалтын гэрээ байгуулж хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна.

Ингэхдээ компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар тендерийн ажил хүлээж авах комиссыг томилж, бараа, ажил үйлчилгээг хүлээж авсан, хүлээлгэн өгсөн, гэрээг дүгнэсэн акт үйлдэн санхүүжилтийг олгосон байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2020-2022 онд явуулсан тендер, хөрөнгө оруулалтын худалдан авалт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №10

/сая.төг/

Д/д	Нэр төрөл	Төсөв	Гэрээний үнэ	Олгосон санхүүжилт	Худалдан авах ажиллагааны төрөл
2020 он					
1	Ажлын хувцас	15.3	14.6	14.6	ХА
2	Ажлын гутал	16.5	15.8	15.8	ХА
	дүн	31.8	30.4	30.4	
2021 он					
1	Цахилгаан нөөц эх үүсгэвэр 400 кВа	100.0	100.0	55.0	НТШ
	Дүн	100.0	100.0	55.0	
2022 он					
1	Цахилгаан нөөц эх үүсгэвэр 400 кВа	100.0		45.0	НТШ
2	ДДТ-дийг автоматжуулах, хяналт удирдлагын системээр тоноглох	139.2	139.2	69.0	НТШ
3	Зуух №3-ын уутат фильтерийн уутыг шинэчлэх	72.0	72.0	72.0	НТШ

4	Зуух №3-ын утаа сорогч, үлээх салхилуурын цахилгаан хөдөлгүүрт давтамж хувиргуур суурилуулах. /90кВт, 55кВт/ авах	30.8	30.8	30.8	ХА
5	Ажлын гутал /өвөл, зун/	22.0	22.0	22.0	ХА
6	Машины дугуй худалдаж авах	21.5	21.5	21.5	ХА
7	Ажлын хувцас /өвөл, зун/	20.7	20.7	20.7	ХА
Дүн		406.2	306.2	281.0	
Нийт дүн		538.0	436.6	366.4	

/Эх сурвалж: “Улаангомын Дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан/

Дээрх хүснэгтээс харахад 2020-2022 онд хэрэгжүүлсэн нээлттэй болон харьцуулалтын арга ашигласан худалдан авалтад олгосон санхүүжилт дараах байдалтай байна. Үүнд:

- ✦ 2020 онд харьцуулалтын аргаар хэрэгжүүлсэн 2 худалдан авалтад 31.8 сая төгрөгийн 2 гэрээ байгуулж, санхүүжилт олгосон,
- ✦ 2021 онд 100.0 сая төгрөгийн 1 нээлттэй тендер шалгаруулж худалдан авалт хийж, гэрээний хугацааг сунгаж он дамжуулан төлбөрийг шилжүүлсэн байна.
- ✦ 2022 онд нээлттэй тендер 3, харьцуулалтын аргаар хэрэгжүүлсэн 4, нийт 306.2 сая төгрөгийн 7 худалдан авалтад гэрээ байгуулж, 281.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

“Брокко хийц” ХХК-тай ДДТ-5, ДДТ-6 засварын ажлын зураг төсөв хийлгэхээр 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 16/2022 дугаар гэрээ байгуулсан байна. Уг ажил гүйцэтгэх гэрээний 2-3-д “Гэрээ батлагдсанаас хойш 14 хоногийн дотор зураг төслийн ажлын тохиролцсон үнийн 50 хувьтай тэнцэх урьдчилгаа төгрөгийг гүйцэтгэгчид төлнө” гэж заасан байхад 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр гэрээний төлбөр 9.1 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн шилжүүлсэн бөгөөд гүйцэтгэгч нь зураг төсвийг хүлээлгэн өгөөгүй байсан. Аудитын явцад “Брокко хийц” ХХК тухайн зураг төсвийг компанийн харуулын байранд хүлээлцсэн акт үйлдэхгүйгээр үлдээсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ”, 19.2 дахь хэсэгт “Тендерийн баримт бичигт тендер оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендер оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасны дагуу 2020-2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тендерийн бичиг баримтыг боловсруулжээ.

Мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2 дахь хэсэгт “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ” гэсэн заалтын дагуу тендерийн хавтаст хэрэг бүрдүүлэн архивын нэгж болгосон байна.

БҮЛЭГ: 4. Бүртгэлд тусгаагүй, ашиглалтгүй хөрөнгө, анхан шатны баримтгүй зарцуулсан бараа материал байгаа нь бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна.

4.1. Үндсэн хөрөнгө, материалын тооллогыг хуулийн дагуу хийсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2 дахь хэсэгт "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 дэх заалтад "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа", 2 дахь хэсэгт "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа" гэж заасны дагуу компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар комисс томилон үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг 2020 онд 1 удаа, 2021 онд 2 удаа, 2022 онд 2 удаа тус тус хийсэн байна. Үүнд:

Хүснэгт №11

№	Тушаалын нэр	Тушаалын огноо, дугаар
1	Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай	2020.12.21 А/30
2	Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай	2021.06.21 А/24
3	Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай	2021.12.21 А/42
4	Эд хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулах тухай	2022.06.27 А/26
5	Эд хөрөнгийн тооллого явуулах тухай	2022.12.22 А54

/Эх сурвалж: Гүйцэтгэх захирлын А, Б тушаалууд/

Үндсэн хөрөнгийн 2020 оны тооллогоор 16,068.3 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө, 104.5 сая төгрөгийн өртөгтэй бараа материал тоолсон байна. Тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй, тооллогын комисс дараах саналыг гаргасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийсэн 5 ДДТ-ийн өргөтгөл, шинээр ашиглалтад орсон 4 ДДТ-ийг 2021 онд улсын комиссын дүгнэлт, акт болон бусад холбогдох материал ирэхээр холбогдох журам зааврын дагуу хөрөнгө орлогд авч.
- Хавсралт тусгагдсан 40 нэр төрлийн 8.9 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг актлах.

Үндсэн хөрөнгийн 2021 оны тооллогоор 16,391.5 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө, 58.6 сая төгрөгийн өртөгтэй бараа материал тоолсон байна. Тооллогын комисс дараах саналыг гаргасан байна. Үүнд:

- Тавилга, эд хогшил дансанд бүртгэлтэй 7 нэр төрлийн 9.4 сая төгрөгийн хөрөнгийг машин, тоног төхөөрөмж дансанд шилжүүлэн бүртгэх.
- Хавсралт тусгагдсан 30 нэр төрлийн 5.3 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг актлах.

Үндсэн хөрөнгийн 2022 оны тооллогоор 11,807.7 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө, 144.1 сая төгрөгийн өртөгтэй бараа материал тоолсон байна. Тооллогын комисс дараах саналыг гаргасан байна. Үүнд:

- Тооллогоор сэнс, хурлын төхөөрөмж, телефон утас, блокийн машин, насос 3 ширхэг, тавийн тоолуур, зурагт 2 ширхэг, автоматжуулалтын рак, камерын хүлээн авагч, автоматжуулалтын шит 8 ширхэг, усны тоолуур 2 ширхэг, автоматжуулалтын компьютер зэрэг хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсныг шинээр бүртгэлд тусгуулжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт, дүгнэх аргачлал батлах тухай” 2020 оны 715 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийг 2020 онд 95.0 хувьтай, 2022 онд 93.7 хувьтай тус тус дүгнүүлсэн байна.

4.2. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр болон бусад эх үүсвэрээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, зарим хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг буруу бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасны дагуу 2020, 2021 онд шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх” хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” гэж заасны дагуу гаргасан шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгажээ. Тухайлбал:

- ТӨБЗГ-ын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан дулаан, хэрэглээний халуун ус, хүйтэн усны 772 метр 5 хос шугамыг 2021 онд,
- ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 565 дугаар тогтоолоор ирсэн CAT438 Экскаваторыг 2021 онд,
- ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 656 дугаар тогтоолоор ирсэн Ландкрузер-105 автомашиныг 2020 онд,
- ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор ирсэн уурын зуухны барилга, нүүрсний агуулах, 568 метр квадрат газрыг 2022 онд тус тус орлого авсан байна.

2020-2022 онд нэмэгдсэн хөрөнгийг дансны ангиллаар харуулбал:

Хүснэгт №12

/сая.төг/

Огноо	Хөрөнгийн нэмэгдсэн төрөл	Барилга, байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө /нийтийн	Программ хангамж	Дүн
2020 он	Өөрөө үйлдвэрлэсэн	1.6							1.6
	Худалдаж авсан		15.9		2.8	14.0			32.8
	Үнэ төлбөргүй хүлээн авсан			78.9					78.9
	Дүн	1.6	15.9	78.9	2.8	14.0	0	0	113.3
2021 он	Худалдаж авсан	0.8	34.9		0.7	8.2			44.6
	Үнэ төлбөргүй хүлээн авсан		816.1						816.1
	Дүн	0.8	851.0	0	0.7	8.2			860.7
2022 он	Худалдаж авсан	23.3	93.7		1.5		58.3	11.4	188.1
	Дүн	23.3	93.7	0	1.5	0	58.3	11.4	188.1
		25.7	960.6	78.9	5.0	22.3	53.3	11.4	1,157.2

/Эх сурвалж: “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Аудитад хамрагдсан 2020 онд 16 нэр төрлийн 113.3 сая төгрөг, 2021 онд 15 нэр төрлийн 860.8 сая төгрөг, 2022 онд 21 нэр төрлийн 188.1 сая төгрөг, нийт 52 нэр төрлийн 1,162.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгджээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчин гадна автомашины граж 3 ширхэг, саравч 2 ширхэг, гадна жорлон, авто зогсоолыг данс бүртгэлд тусгаагүй зөрчил байсанд хөрөнгийг данс бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлжээ.

Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж хийгдсэн ДДТ-ыг автоматжуулах, хяналт удирдлагын системээр тоноглох 139.2 сая төгрөгийн ажлыг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авсан боловч санхүүгийн тайланд бүртгээгүй, 2023 оны 1 дүгээр сард бүртгэлд тусгасан байна.

Мөн 2022 оны 8 дугаар сард 7.4 сая төгрөгийн 1 ширхэг 55 квт-ын давтамж хувиргагч, 20.6 сая төгрөгийн 2 ширхэг 90 квт-ын давтамж хувиргагчийн элэгдэл тооцох хугацааг 60 сар байхыг 5 сараар, 2022 оны 12 дугаар сард 86.4 сая төгрөгийн 400 квт-ын дизель генератор, 12.7 сая төгрөгийн сэндвичин байрны элэгдэл тооцох хугацааг 120 сар байхыг 10 сараар тус тус буруу бүртгэсэн байна. Хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг үнэн зөв бүртгэж, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллахыг зөвлөв.

4.3. Бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас ашиглалтгүй хөрөнгө хадгалагдаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий нягтлан бодогч, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна” гэж заасны дагуу “Улаангомьын дулааны хоёрдугаар дугаар станц” ТӨХК-ийн өмч хамгаалах зөвлөлийг байгуулсан байна. Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/25 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан ч тухайн зөвлөл үйл ажиллагаа явуулаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1-д “Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэж заасны дагуу өмч хамгаалах байнгын зөвлөл нь хуралдаж эд хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, тооллогын болон техникийн комиссын шийдвэр гарсан актлах үндсэн хөрөнгийн жагсаалтыг ТУЗ-өөр хэлэлцүүлээгүй, хөрөнгө актлах тухай тогтоол гаргуулаагүй байна.

Аудитын явцад үндсэн хөрөнгийн тооллого хийхэд ашиглалтгүй хадгалагдаж байгаа дараах үндсэн хөрөнгүүд байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 656 дугаар тогтоолоор Ховд аймгийн Булган сум дахь сум дундын Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий Ланд круйзер-105 автомашин 2020 онд балансаас баланст шилжүүлсэн,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 565 дугаар тогтоолоор “Ховд АЗЗА” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 66.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий Экскаватор САТ438-ыг 2020 онд балансаас баланст шилжүүлсэн,

- 2022 онд Апекс санхүүгийн программ ашиглаж эхэлснээр хуучин ашиглаж байсан 2017 онд авсан 1.3 сая төгрөгийн үнэ бүхий МАКС программ, 2018 онд авсан 2.4 сая төгрөгийн үнэ бүхий Винница программ тус тус ашиглалтгүй хадгалагдаж байна.

Түүнчлэн 2018 онд ашиглалтад хүлээн авсан 98.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий 36.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй шанагатай ачигч ковш 2021, 2022 онд эвдэрч засвар үйлчилгээ хийсэн боловч дахин эвдэрч тухайн компани түрээсийн гэрээгээр ковш ажиллуулан ирсэн бөгөөд одоо ашиглалтгүй хадгалагдаж байна.

4.4. Эдэлгээний нөөцийн доод хязгаарын нормыг тооцохгүйгээр хөрөнгө, материал худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд тооллого хийхэд хэрэгцээнээс илүүдэлтэй бэлтгэсэн хөрөнгө, материал байхгүй байна.

Харин Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм"-ын 5.1 дэх хэсэгт "Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө" гэж заасан байхад дугуй болон аккумуляторыг эдэлгээний доод хязгаарын нормыг тооцохгүйгээр худалдан авсан. Мөн "Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын нормыг тухайн эд ангийг үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийг үндэс болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөнө" гэж заасан байхад үндсэн агрегат, зангилаануудын эд ангийг доод хязгаарын нормыг тооцохгүйгээр худалдан авсан байна.

Цаашид Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм"-ыг мөрдөж ажиллахыг зөвлөв.

4.5. Шатах тослох материалын зарцуулалтад тогтоосон норм, стандартыг мөрдөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан байна.

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, ТУЗ-ийн баталсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу шатах тослох материалын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтад "Энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах", 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт "Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна" гэж заасны дагуу "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн захирлын тушаалаар үнэлгээний хороог байгуулсан байна. Үүнд:

- 2020 онд А/06 дугаар тушаалаар УДС2/202001002 дугаартай бензин, шатахуун нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй,

- 2021 онд А/10 дугаар тушаалаар УГД2СТӨХК/2021030203 дугаартай бензин, шатахуун нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй,
- 2022 онд А/08 дугаар тушаалаар УГД2СТӨХК/202201001 дугаартай бензин, шатахуун нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнэ”-ийг баримтлан шатах тослох материалын тендерийг 2020-2022 онд зарласан байна.

Аудитад хамрагдсан онуудад тендер худалдан авалтад шалгарсан харилцагч байгууллага, төсөвт өртөг дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №13

/сая.төг/

Он	Худалдан авах ажиллагааны төрөл	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан компани
2020	НТШ	31.2	29.1	Баялаг Увс ХХК
2021	ХА	45.6	33.5	НИК ХХК
2022	НТШ	311.9	302.6	Ундарга Увс ХХК

/Эх сурвалж: Улаангомын дулааны станц ТӨХК-ийн тендер худалдан авалтын баримт/

Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.8 дахь заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчиж 2022 онд 9.7 сая төгрөгийн 2616 литр шатах тослох материалыг нүүрс тээвэрт явсан 9 жолоочийн тээврийн хөлснөөс суутган тооцоогүй, шатахууны тооцоо бодохдоо өр төлбөр, авлагын бүртгэл хөтлөөгүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Авто машины шатахуун зарцуулалтын шинэчилсэн норм” баталсан тушаалын 1-р хавсралт “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг мөрдөн ажиллаагүйгээс 2020 онд 34.1 сая төгрөгийн 16118 литр, 2021 онд 26.8 сая төгрөгийн 12089 литр, 2022 онд 22.0 сая төгрөгийн 6579 литр, нийт 82.9 сая төгрөгийн 34786 литр шатах, тосох материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан, зарцуулалтын тооцоо бодоогүй зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**БҮЛЭГ: 5 Компанийн дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, шат шатны
хяналт үр дүнгүй байна.****5.1. Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр дүнгүй байна**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно", 81.2 дахь хэсэгт "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ" гэж заасан байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 11 дүгээр, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар, 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар тогтоолуудаар компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг шинэчлэн байгуулан ажилласан байна.

Аудитад хамрагдсан онуудад цар тахлын улмаас үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр хяналт шалгалтын давтамж багасаж, ажлын байрны зураг авалт, газар дээр нь ирж ажиллах нөхцөл боломж буурснаар дотоод аудит, эрсдэлийн удирдлагын үр нөлөө буурах эрсдэл үүссэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн хянан шалгах хороо, Сангийн яам болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ" гэж заажээ.

Аудитад хамрагдсан онуудад "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн хувьд Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яам, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас холбогдох чиглэл, албан даалгавар, зөвлөмж, мэдээлэл өгч хэрэгжилтэд хяналт хийсэн байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 20/07/033/15 дугаартай удирдамжаар "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн дулааны эх үүсвэр, зуух даралтат сав, шугам хоолойн ашиглалт аюулгүй ажиллагаа болон дулаан үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа, тэдгээрийн шугам сүлжээний ашиглалт, аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийж хяналтын хуудсаар үнэлгээ өгсөн,
- ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 22-01/22 дугаартай удирдамжаар 2021 оны үйлдвэрлэл, удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж 10 зөвлөмж өгсөн,
- ✓ Эрчим хүчний яамнаас Эрчим хүчний салбарын тарифын хэлэлцээрийн гэрээний биелэлт ирүүлэх, техникийн нөхцөл олголтыг шуурхай шийдвэрлүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, худалдан авах ажиллагаанд анхаарч ажиллах, авлага, өр төлбөр барагдуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хариуцлагатай жижүүр эргүүл томилох, ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж томилох,
- ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Хөрөнгийн бүртгэл, хөтлөлт тайлан мэдээ ирүүлэх, чиглэл өгөх, зөвлөмж хүргүүлэх, компанийн зорилтот түвшний төслийн тухай судалгаа гаргуулах,
- ✓ Мэргэжлийн хяналтын газраас Хяналтын шалгалтын мөрөөр зөвлөмж чиглэл өгөх, хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар,
- ✓ Эрчим хүчний хөгжлийн төвөөс өр, авлага барагдуулах тухай, судалгаа мэдээ ирүүлэх зэргээр хамтран ажилласан байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн аудитад хамрагдсан онуудын санхүүгийн үйл ажиллагаанд Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээс хяналт шалгалт хийгдээгүй байна.

Харин Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Увс аймаг дахь Төрийн аудитын газар, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ҮАГ-тай гэрээ байгуулсан хөндлөнгийн аудитын компани аудит хийж дүгнэлт гаргасан. Аудитаар 2020 онд 57.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж, 2022 онд 4 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49 дэх заалтад “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг” гэж заажээ. Аудитад хамрагдсан 2020-2022 онд дотоод аудиторын орон тоо байгаагүй байна. Харин компанийн ТУЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор орон тооны 1 дотоод аудитортой болсон байна.

Эрчим хүчний яамнаас 2022 онд “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл, хүний нөөц, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт, санхүүгийн дотоод хяналтын хэрэгжилтэд Эрчим хүчний сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж 11 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 252 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч хангалтгүй гэж үзэж 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дахин ирүүлэхийг үүрэг болгосон байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дах заалтад “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.2 дах хэсэгт “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалтад “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтад “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй дараах зөрчлүүд байна. Үүнд:

- “Брокко хийц” ХХК-тай ДДТ-5, ДДТ-6 засварын ажлын зураг төсөв хийлгэхээр 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 16/2022 дугаартай гэрээ байгуулсан байна. Уг ажил гүйцэтгэх гэрээний 2-3-д “Гэрээ батлагдсанаас хойш 14 хоногийн дотор зураг төслийн ажлын тохиролцсон үнийн 50 хувьтай тэнцэх урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид төлнө” гэж заасан байхад 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр гэрээний төлбөр 9.1 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн шилжүүлсэн бөгөөд гүйцэтгэгч нь зураг төслийг компанид хүлээлгэн

өгөөгүй байсан. Аудитын явцад "Брокко хийц" ХХК-аас тухайн зураг төсвийг "Улаангомын дулаан хоёрдугаар станц" ТӨХК-ийн харуулын байранд хүлээлцсэн акт үйлдэхгүйгээр үлдээсэн байна. Компанийн одоо ажиллаж байгаа гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч тухайн зураг төсөв хийлгэсэн талаар мэдээлэлгүй байсан.

- Машин механизмыг түрээсээр ажиллуулах тухай 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хувь иргэнтэй байгуулсан гэрээний 3.1-д "Машин механизмын ажилласан бодит цаг, хоногийн хэмжээгээр гүйцэтгэлийн төлбөр тооцогдоно", 3.2-д "Түрээсээр ажилласан машин механизмын гүйцэтгэлийн сар бүрийн эцсээр тасалбар болгон акт үйлдэх ба төлбөрийг 10 өдөрт багтаан төлнө" гэж заасан байхад 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Ковш түрээсийн төлбөр гэж 15.0 сая төгрөг шилжүүлсэн, мөн 2022 оны санхүүгийн тайланд өглөг тусгаагүй байхад 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 5.3 сая, 2 дугаар сард 17-ны өдөр 3.0 сая, 5 дугаар сарын 16-ны өдөр 7.0 сая, нийт 15.3 сая төгрөгийг урд оны тооцоо нэрээр үндэслэх анхан шатны баримтгүй шилжүүлснийг холбогдох ажилтнаас тодруулан баримт шаардахад ажил гүйцэтгэсэн иргэний гар утсанд ирсэн чатын зураг, жижүүрийн хөтөлсөн бүртгэл зэрэг баримтыг нөхөн ирүүлсэн,
- Ажил гүйцэтгэх 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаартай гэрээний дагуу үнс ачилтын хөлс гэж 1 иргэнд 1.7 сая төгрөг, "Хос алтан зам" ХХК-д үнс ачилтын хөлс гэж 2.2 сая төгрөг шилжүүлсэн байна. Уг баримтад 32 удаагийн ачилт гэсэн нэхэмжлэх байгаа хэдий ч 32 ачилт хийснийг нотлох анхан шатны баримт байхгүй байна. Тодруулахад ерөнхий инженерийн бүртгэлийн дэвтэр, хамт олны цуглааны бүртгэл зэрэг баримтыг нэмэлтээр харуулсан,
- Албан томилолтын хуудсанд ажилласан байгууллагын нэр, тамга тэмдэг байхгүй, өөрийн компанийн тамга тэмдэг дарсан, ирсэн явсан өдрийг тэмдэглээгүй, тэмдэглэсэн хоногийг зөрүүтэй тооцож олгосон, буцаж ирэхэд албан томилолтын хуудсанд томилсон эрх бүхий албан тушаалтан хэдэн хоног, хэдэн хувиар тооцож олгохыг тэмдэглэдэггүй зэрэг зөрчлүүд байна.

Мөн 2022 онд борлуулалт хариуцсан байцаагч нар банкны хуулгаар орж ирээгүй 23 иргэний 2.4 сая төгрөгийн төлбөрийг төлсөн гэж бүртгэсэн байсныг тодруулахад төлбөр төлсөн иргэний мөнгөөр бусад иргэний төлбөрийг хааж бичилт хийсэн, байцаагч нар өөрийн сарын нормыг гүйцэтгэхийн тулд хэрэглэгчийн төлбөрийг хоорондоо шилжүүлэн бичилт хийсэн, нэг хэрэглэгчийн төлсөн мөнгөөр хэд хэдэн хэрэглэгчийн төлбөрийг хааж бичилт хийсэн байна.

Энэхүү зөрчлүүдээс харахад компанийн үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих шат шатны хяналт хариуцлага сул, дотоод хяналт хангалтгүй байна.

Цаашид дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зөвлөмж өгөв.

5.2. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг оновчгүй төлөвлөсөн, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийгээгүй нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтад "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасны дагуу компанийн гүйцэтгэх захирал нь жил бүр компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө боловсруулж ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг ханган ажиллаж байна.

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №14

/сая.төг/

д/д	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж		2020 он		2021 он		2022 он	
					төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Боловсруулсан		ДЭХ	м.Гкл	42.4	47.3	46.8	55.6	58.0	69.2
	Шугамын алдагдал		Биет зэр	м.Гкл	4.2	2.40	2.3	2.80	2.9	3.40
	Эрчим хүч түгээлт		ДЭХ	м.Гкл	38.2	44.9	44.5	52.8	55.1	65.8
2	Нийт орлого		сая.төг		2,766.5	2,781.9	3,132.2	3,335.4	3,837.3	3,891.6
	Үүнээс	Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг		2,650.6	2,642.2	3,032.1	3,211.4	3,555.5	3,609.8
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг		115.9	139.7	100.0	124.0	100.0	100.0
		Санхүүжилт /Улсын төсвийн татаас/							181.8	181.8
3	Нийт зардал		сая.төг		3,041.4	3,239.9	3,321.4	3,504.4	4,512.6	4,817.8
	Үүнээс	Үйл ажиллагааны зардал	сая.төг		3,041.4	3,239.9	3,321.4	3,504.4	4,512.6	4,817.8
		Үүнээс: Удирдлагын зардал	сая.төг				71.2	53.7		
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг		-	-	35.9			
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		сая.төг		71.1	47.7			783.4	783.4
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг		(274.9)	(458.0)	(189.2)	(169.0)	(675.3)	(926.1)
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг		(274.9)	(458.0)	(189.2)	(169.0)	(675.3)	(926.1)
6	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал		Төг		1.10	1.23	1.06	1.05	1.18	1.33
7	Нийт авлага		сая.төг		215.8	267.8	171.2	307.6	138.7	293.2
8	Нийт өглөг		сая.төг		1,097.6	1,030.6	623.1	591.7	614.9	953.1
	Үүнээс	Урт хугацаат өр төлбөр	сая.төг		-					
		Богино хугацаат өр төлбөр	сая.төг		1,097.6	1,030.6	623.1	591.7	614.9	953.1
9	Нийт ажиллагсдын тоо		Тоо		90	90	93	93	93	93
10	Нийт цалингийн сан		сая.төг		854.6	851.6	981.8	967.0	1,245.5	1,307.9
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг		181.1	25.2	154.0	142.8	521.5	362.3

/Эх сурвалж: "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлан/

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд гүйцэтгэлээр 2,781.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,239.9 сая төгрөгийн зардал гарган 458.0 сая, 2021 онд гүйцэтгэлээр 3,335.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,504.4 сая төгрөгийн зардал гарган 169.0 сая, 2022 онд гүйцэтгэлээр 3,891.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,817.7 сая төгрөгийн зардал гарган 926.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажиллахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Компанийн эзэмшлийн техник хэрэгсэл хангалтгүй, ашиглалтын шаардлага хангахгүй болсноос шалтгаалан байнгын засвар үйлчилгээ хийж байгаа болон нүүрс тээврийг гаднын машинаар гүйцэтгүүлж, ковш, үнс тээвэрлэх автомашин түрээсэлж нэмэлт зардал гарсан,
- Хэрэглэгчдийн тоо нэмэгдсэнээс "Улаангомын дулааны станц" ТӨХК-ийн орлого нь 2020-2022 оны хооронд 16-20 хувийн өсөлтэй байгаа хэдий ч аудитад хамрагдсан онуудад цахилгаан, усны тариф, шатах тослох материал, бараа бүтээгдэхүүний үнэ өссөн,
- Өмнөх онуудад үүссэн өр төлбөрийг шүүхийн шийдвэрээр төлж барагдуулсан,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал жил бүр өссөн,
- Дотоод хяналт хангалтгүйгээс хууль тогтоомж зөрчин үргүй зардал гаргасан,
- Аж ахуйн нэгжүүдийн дулаан түгээх эзлэхүүний хэмжээг гэрээнд бодит хэмжилтээс дутуу тооцож тусгаснаас нийлүүлсэн дулааны орлогыг дутуу төвлөрүүлж байгаа.

5.3. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг 94.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

"Улаангомын Дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн 2020-2022 оны жил эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт дараах байдалтай байна.

Хүснэгт №15

/сая.төг/

Д/д	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Огноо	Шийдвэрлэсэн байдал	Биелэлт
1	Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, үнэлгээ, хариуцлага, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаж, компанийн дүрэм дээрх төрийн өмчийн дүнг залруулж, санхүүгийн тайлангийн балансын дүнтэй тохируулж дүрэм дээр заасан дүнг 2,925.2 сая төгрөгөөр бууруулах.	2,925.2	2020	Зөвлөмж	100%
2	Цахим баримтын ebarimt.mn системийн 1,032.0 сая төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 57.7 сая төгрөгийн худалдан авалтын и-баримт цахим системд бүртгэлгүй байна.	57.7	2020	Албан шаардлага	100%
3	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 120 мэдээллийг хугацаанд нь, 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	2020	Албан шаардлага	100%
4	Тайлант онд 1 ажилтанд цалингийн урьдчилгааг сарын цалингаас 8 дахин хэтрүүлж 7.5 сая төгрөг олгосон байна.	7.5	2022	Зөвлөмж	62.7%
5	Ажилтнуудад олгосон 10.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг тайлант хугацаанд суутган тооцоогүй байна.	10.6	2022	Зөвлөмж	100%
6	Улаангомын политехник коллежтой тооцоо нийлсэн 54.1 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгах.	54.1	2022	Зөвлөмж	100%
7	Тайлант хугацаанд борлуулалтын орлого дутуу тайлагнасан.	2.2	2022	Зөвлөмж	100%
	Дундаж хувь				94.6

/Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын статистик мэдээ/

5.4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хэвийн байна.

Шилэн дансны тухай хууль батлагдсанаар төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоо бүрдсэн билээ. Хуулийн 3 дугаар бүлгийн 3.1 дэх хэсэгт “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна”, 3.1.3-д “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани” гэж заасан байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заажээ. Үүнд:

- 6.8.1.Тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр;
- 6.8.2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;
- 6.8.3.Төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт гэж тусгасан байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудиторын газраас 2022 оны 4 дүгээр сард хийсэн хяналт шалгалтаар төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд хамрагдаагүй, Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүртгэлээр тайлагнасан байсанд шилэн дансны талбарыг орон нутгийн талбараас Эрчим хүчний сайдын цэсэд шилжүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн” –д албан шаардлага өгч байжээ.

Аудитын явцад хянахад шилэн дансны цахим хуудаст 2021 онд мэдээллийг бүрэн байршуулсан, 2022 онд 4 мэдээллийг байршуулаагүй байна. Мөн компани санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбарт санхүүгийн мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Цаашид шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажиллахыг зөвлөв.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аудитад хамрагдсан 3 жилийн хугацаанд компанийн гүйцэтгэх захирал 4 удаа, ерөнхий нягтлан бодогч 3 удаа солигдсон нь дотоод хяналт алдагдахад нөлөөлсөн байна.
2. Компанийн үндсэн үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, машин, техник хэрэгсэл хүрэлцээгүй, үргүй зардал гаргасан зэргээс шалтгаалан алдагдалтай ажиллаж байгаа нь компанийн засаглалыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.
3. ТУЗ-өөр батлуулсан зардлыг 2020 онд 198.5 сая, 2021 онд 183.0 сая, 2022 онд 305.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
4. Нүүрсний төлбөр тооцоотой холбоотой маргаанаас үүссэн өр төлбөрийн алдангид нийт 155.5 сая, шүүхийн шатанд эвлэрлийн гэрээ байгуулж пүүний зөрүүнээс үүссэн 59.8 сая, тэмдэгтийн хураамжид 3.5 сая, нийт 218.8 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.
5. Анхан шатны баримтын хүчин төгөлдөр, иж бүрэн байдал хангалтгүй, авлага, өр төлбөрийг буруу тайлагнасан, худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулаагүй, үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул байгаа нь компанийн НББ-ийн бодлогын баримт бичгийн мөрдөлт, үйл ажиллагаанд тавих шат шатны хяналт хариуцлага сул байгааг харуулж байна.

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМАГ
"УЛААНГОМЬН ДУЛААНЫ
ХОЁРДУГААР СТАНЦ" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

5 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85169
Утас: 7045-3310
Цахим шуудан: info@ulaangomdulaan.mn

2023.10.03 № 340

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагын 2020-2022 оны санхүүгийн
үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлантай танилцсан болно.

Иймд тухайн тайлангийн талаар санал байхгүй
байна.

ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Э.БААТАРСАН

8522410599

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх хариу тайлбар

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК нь гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн хариу ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захирал Э.Баатарсан нарт:

1. Компанийн засаглалыг сайжруулах замаар үйл ажиллагаанд тавих шат шатны хяналт хариуцлагыг нэмэгдүүлж, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Э.Баатарсанд:

1. Аж ахуйн нэгжүүдийн дулаан түгээх эзлэхүүнийг нягтлан шалгаж хэмжилт хийсний үндсэн дээр гэрээг шинэчлэн байгуулж орлогыг бүрэн төвлөрүүлэх.
2. Компанийн алдагдалд дүн шинжилгээ хийж, батлагдсан зардлыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах.
3. Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үндсэн хөрөнгийн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
4. Санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийг үнэн зөв илэрхийлж, авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулах.
5. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах.

АУДИТЫН ТАЙЛАНГ
ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

АХЛАХ АУДИТОР

ТАЙЛАН БИЧСЭН:

Б.АВИРМЭД
Т.НАМЖИЛ
С.БАТСАЙХАН

АУДИТОР

Ч.МӨНХТОГТОХ
Б.ОДГЭРЭЛ
Т.ЗОЛОО
Т.АМАРМЭНД
А.НАНЖИДМАА